



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ти Ди Би Капитал УЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Сайнбаяр овогтой Батчимэгийг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хорооны даргын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 197 дугаар тушаалаар томилогдсон Товуудорж овогтой Даваажавыг томилсон зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ти Ди Би Капитал УЦК” ХХК /С.Батчимэг/-д үүрэг болгосугай.
  - 1/ Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;
  - 2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН